

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ  
ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эвлэрүүлэн зуучлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

#### **1/58 дугаар зүйлийн 58.5 дахь хэсэг:**

“58.5.Зохигчид шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө эвлэрүүлэн зуучлалд хандаж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон боловч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй дуусгавар болсон бол улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг 25 хувиар бууруулж төлнө.”

#### **2/59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэг:**

“59.7 Энэ хуулийн 74<sup>1</sup>.5-т заасны дагуу талууд эвлэрсэн, эсхүл 74<sup>1</sup>.6-т заасны дагуу зохигчид эвлэрсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эвлэрүүлэн зуучлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7<sup>1.1</sup> дэх хэсгийн “30 000 төгрөгийн” гэснийг “40 800 төгрөгийн” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Эвлэрүүлэн зуучлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг